

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ... дугаар
сарын-ны өдөр

Улаанбаатар
хот

**ГААЛИЙН АЛБАН ТАТВАРЫГ ХӨНГӨЛЖ,
БУЦААН ОЛГОХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Дорноговь аймгийн Сайншанд сумын нутагт барих газрын тос боловсруулах үйлдвэрийн ажилчдын хотхоны барилга байгууламжийн үндсэн хөрөнгө бий болгоход шаардагдах, дотоодын үйлдвэрлэлээс хангах боломжгүй бараа материалд тухайн татварын жилд ногдуулан төлсөн гаалийн албан татварыг 100 хувь хөнгөлж дараа жилийн эхний улиралд багтаан буцаан олгосугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийн 1 дүгээр зүйлд заасан бараа материалын жагсаалтыг “Бараа тодорхойлох, кодлох уялдуулсан систем /БТКУС/”-ийн ангиллын дагуу Засгийн газар батална.

3 дугаар зүйл. Энэ хуулийг батлагдсан өдрөөс эхлэн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл хугацаанд дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ... дугаар
сарын-ны өдөр

Улаанбаатар
хот

НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Дорноговь аймгийн Сайншанд сумын нутагт барих газрын тос боловсруулах үйлдвэрийн ажилчдын хотхоны барилга байгууламжийн үндсэн хөрөнгө бий болгоход шаардагдах, дотоодын үйлдвэрлэлээс хангах боломжгүй, импортоор оруулж ирэх бараа материалыг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийн 1 дүгээр зүйлд заасан бараа материалын жагсаалтыг "Бараа тодорхойлох, кодлох уялдуулсан систем /БТКУС/"-ийн ангиллын дагуу Засгийн газар батална.

3 дугаар зүйл. Энэ хуулийг батлагдсан өдрөөс эхлэн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл хугацаанд дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ